



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 43


Улаанбаатар хот

“Юнайтэд секьюритс ҮЦК” ХХК-ийн  
тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4, 63 дугаар зүйлийн 63.1.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 11.1.3, 11.1.4, 11.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Юнайтэд секьюритс ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.
2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлийг арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг “Юнайтэд секьюритс ҮЦК” ХХК /Г.Хүрэлбаатар/-д анхааруулсугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000613